



БАТЛАВ. МДХ-НЫ ЕРӨНХИЙ НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

Ч.Бат-Эрдэнэ

Ч.БАТ-ЭРДЭНЭ

2017 ОНЫ БАГИЙН УЛСЫН АВАРГА ШАЛГАРУУЛАХ ТЭМЦЭЭНИЙ УДИРДАМЖ

Нэг. Нийтлэг зүйл

1. Тэмцээний зорилго нь 2017 оны Насанд хүрэгчдийн Улсын аварга баг тамирчдыг шалгаруулах, даамын спортыг сурталчилж хөгжүүлэх, түгээн дэлгэрүүлэхэд оршино.
2. Тэмцээнд оролцох багийн бүрэлдэхүүн:
 - Насанд хүрэгчид эрэгтэй 2, ахмад 1 (55 наснаас дээш), эмэгтэй 1, 16 хүртэлх насны хүүхэд 1
 - Нэг багт Дэлхийн даамын холбооны мастер болон түүнээс дээш олон улсын цолтой тамирчин 1 байна.
3. Тэмцээн Монголын даамын холбооны тэмцээний дүрмийн дагуу явагдана.

Хоёр. Тэмцээний журам

1. Тэмцээн 2017 оны 12-р сарын 8-наас 10-ны өдрүүдэд явагдана. Байрыг жич зарлана.
2. Тэмцээний техникийн зөвлөгөөн 2017 оны 12-р сарын 8-ны 12:00 цагт тэмцээний байранд болно. (Цаг өөрчлөгдөж болзошгүй)
3. Тэмцээний хураамж багийн 60,000 төг, блиц тэмцээний багийн хураамж 25,000төг
4. Тэмцээний шүүгчдийн бүрэлдэхүүнийг Монголын даамын холбоо томилно.
5. Мэдүүлгийг 2017 оны 12-р сарын 6-ныг дуустал хүлээн авна.
6. Тэмцээн швейцарь системээр 7-9 өрөг тоглож дүнг гаргана.
7. Цагийн хяналт талдаа 1 цаг 10 минут, блиц 5мин+2сек
8. Багийг хожлын тоогоор цуваагаар байр эзлүүлэн, хожлын тоо тэнцсэн үед дараах шалгуурыг дараалан баримталж дүн гаргана.
 - Багуудын хоорондын тоглолтын харьцаа
 - Багийн бүх гишүүдийн хожлын онооны нийлбэр
 - Швейцарь системийн коэффициент

Гурав. Шагнал, урамшуулал

1. Үндсэн болон блиц тэмцээнд эхний гурван байрт шалгарсан багийг медаль, диплом, мөнгөн шагналаар шагнана.
2. Үндсэн тэмцээний ширээ бүрт түрүүлсэн тамирчныг диплом, мөнгөн шагналаар шагнана.

Лавлах утас: 9916-4205
www.mondaam.mn/2017/team/